



ВИДЕО КОНТЕНТ, ПОДКАСТ
БҮТЭЭГЧ КОМПАНИУДАД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Нам Ян Жугийн гудамж 32/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,
Цахим шуудан: info@nccd.gov.mn,
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2026.08.26 № 3-3/1175
танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Манай төвөөс БЗДХ, ХДХВ, ДОХ-ын талаар нийт хүн ам, эрсдэлт бүлгийн хүн амд шинжлэх ухааны нотолгоонд суурилсан эрүүл мэндийн мэдээ мэдээлэл хүргэх үйл ажиллагааны хүрээнд ХДХВ-ийн өөрийгөө шалгах оношлуурын тухай мэдээлэл сурталчилгааны видео контент бүтээлгэхээр төлөвлөж байна. Эрүүл мэндийн боловсрол, нийгмийн эерэг хандлагыг дэмжсэн **видео контент** бүтээгч байгууллагуудыг хамтран ажиллахыг урьж байна. Энэхүү үйл ажиллагааг 8,000,000 (найман сая) төгрөгийн төсөвт өртгөөр хийлгэх тул видео контент бүтээгч компаниуд үнийн саналаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дах заалтын дагуу 2026 оны 09 дүгээр сарын 07-ны дотор ирүүлнэ үү.

Саналыг байгууллагын албан тоотоор баталгаажуулж холбогдох материалын бүрдэл (улсын бүртгэлийн гэрчилгээ, ижил төстэй ажлын гэрээ, мэдээлэл)-ийг ханган tender@nccd.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

D2H төслийн хүрээнд “Өөрийгөө шалгах оношлуур”-ын тухай мэдээлэл сурталчилгааны видео контент бүтээх ажлын даалгавар

№	Үйл ажиллагаа	Тоо хэмжээ	Тавигдах шаардлага
1	Өөрийгөө шалгах оношлуурын тухай мэдээлэл хүргэх видео контент	- 4 төрлийн богино хэмжээний видео	- Видео контент нь агуулга найруулгын алдаагүй, энгийн ойлгомжтой байх - Дуу, дүрсний өндөр чанартай (full HD/4K) тайлбар бичвэр (subtitle), анимейшн зэрэг мультимедиа элементийг багтаасан байх - Олон нийтийн цахим сүлжээн (TikTok, Facebook Reels, Instagram Reels, YouTube Shorts)-д ашиглах боломжтой байх
2	Бүрдүүлэх материал	- Үнийн санал - Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - Ижил төстэй ажил (видео контент, медиа бүтээл, нэвтрүүлэг) гүйцэтгэж байсан ажлын гэрээ, бүтээлийн жишээ холбоос (2-оос доошгүй)	

ЗАХИРАЛ

С.ЭНХБОЛД

